



САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТ

Говь-Алтай аймаг дахь Мэргэжлийн боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2025/093/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2025 он	Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Цэцэгмаа Утас: 99488754 Цахим хаяг: tsetsegmaab@audit.gov.mn Ахлах аудитор: Г.Энхдэлгэр Утас: 99002291 Цахим хаяг: enkhdelgerg@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл /мянган төгрөгөөр/

	Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	619,561.4	694,049.7
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,593,303.8	2,543,067.0
	Нийт хөрөнгийн дүн	3,212,865.2	3,237,116.7
	Нийт өр төлбөрийн дүн	121,073.9	218,200.0
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,091,791.3	3,018,916.6
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,212,865.2	3,237,116.7
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	2,729,443.0	3,387,502.2
	Үйл ажиллагааны зардлын дүн	2,962,970.3	3,437,493.0
	Үйл ажиллагааны үр дүн	(233,527.3)	(49,990.7)
	Үйл ажиллагааны бус үр дүн	0	(21,102.8)
	Үйл ажиллагааны нийт үр дүн	(233,527.3)	(71,093.5)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,325,318.6	3,091,791.3
	Тайлант оны үр дүн	(233,527.3)	(71,093.5)
	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	357,4920.8	(1,781.1)
	Эцсийн үлдэгдэл	3,091,791.3	3,018,916.6
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	2,682,286.4	3,272,579.9
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	2,678,418.4	3,135,579.3
	Үйл ажиллагааны ЦМГ	3,868.0	137,000.6
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(3,868.0)	(39,628.7)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	0	0
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	0	97,371.8
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	97,371.8
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	3,491,934.6	3,175,208.0
	Урсгал зардал	3,491,934.6	3,175,208.0
	Хөрөнгийн зардал		
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	3,491,934.6	3,272,579.9
	Улсын төсвөөс санхүүжих	2,563,099.9	2,563,099.9
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	889,205.3	662,420.6
	Үндсэн үйл ажиллагааны орлого	18,429.4	25,509.4
	Туслах үйл ажиллагааны орлого	21,200.0	21,550.0

Гурав. Аудитын илрүүлэлт:

Залруулсан алдаа

Аудитаар бүртгэл тайлагналын алдаа¹ илрээгүй. Залруулга хийгдээгүй.

Залруулагдаагүй нийт 34,039.4 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 34,039.4 мянган төгрөгийн 4 зөрчил² илэрсэнд 1 төлбөрийн акт, 3 албан шаардлага хүргүүлсэн.

Төлбөрийн акт

1. Жолооны сургуулийн сургалтын үйл ажиллагааны чиглэлээр төрийн өмчийн байрыг түрээсэлж орлого олсон боловч улсын төсөвт төвлөрүүлэх 400.0 мянган төгрөгийг төвлөрүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх"; Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 49 дүгээр "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод хязгаар, түрээсийн зарим төлбөрийн хэмжээг тогтоох заавар, улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хувь хэмжээг шинэчлэн батлах тухай" тогтоолын 2-т "Түрээсийн орлогоос улсын төсөвт төвлөрүүлэх хэмжээг нийт орлогын 40 /дөчин/ хувиар тогтоосугай" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоосон.

Албан шаардлага

1. Сургуулийн өрөө тасалгааг жолооны сургуулийн сургалтын үйл ажиллагааны чиглэлээр түрээслүүлж гэрээ байгуулахдаа түрээсийн төлбөрийн доод хязгаарыг бууруулж түрээсийн төлбөр авахаар тусгасан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх"; Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 49 дүгээр тогтоолын хавсралт "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод хязгаар, түрээсийн зарим төлбөрийн хэмжээг тогтоох заавар"-ын 1-т /Бусад 5000 төгрөг/, 2-т "Түрээсийн төлбөрийн доод үнийг тодорхой шалтгаанаар бууруулан тогтоох асуудлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар тавьж шийдвэрлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Түрээсийн төлбөрийг зохих журмын дагуу тооцож, гэрээг шинэчлэн байгуулж, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/;

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

2. Сургуулийн дотуур байранд Шагай харвааны клуб түрээсгүйгээр, гэрээ байгуулаагүй үйл ажиллагаа явуулж байгаа нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх"; Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 49 дүгээр тогтоолын хавсралт "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод хязгаар, түрээсийн зарим төлбөрийн хэмжээг тогтоох заавар"-ын 1-т /Бусад 5000 төгрөг/, 2-т "Түрээсийн төлбөрийн доод үнийг тодорхой шалтгаанаар бууруулан тогтоох асуудлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар тавьж шийдвэрлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг зохих журмын дагуу бусдад ашиглуулж, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

3. Бараа үйлчилгээний бусад зардлаас сургалтын хэрэглэгдэхүүн 26,890.0 мянган төгрөгөөр бэлтгэхдээ худалдан авах ажиллагаа зохион байгуулалгүй шууд худалдан авалт хийсэн нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно." гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Босго үнээс давсан төсөвт өртөг бүхий зардалд худалдан авах ажиллагаа зохион байгуулахгүй байгаа зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/ сая төгрөгөөр/ Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Мэргэжлийн боловсролын сургууль												
Дүн	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт зөрчил		/сая төгрөгөөр/ Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Мэргэжлийн боловсролын сургууль	4	34.0	1	0.4	3	33.6	-	-	-	-	-	-
Дүн	4	34.0	1	0.4	3	33.6	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		/сая төгрөгөөр/ Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн	-	-	-	-	-	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-
-Нийт дүн	-	-	-	-	-	-	-	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр						
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй	Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ		1			1			
	НИЙТ		1			1			